



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 1/1433

Алтай хот


Гамшгийн сангаас хөрөнгө  
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Гамшгийн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам, аймгийн Онцгой комиссын 2022 оны 07 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сэлэнгэ аймагт зохион байгуулах “Олон Улсын гүний усны дадлага сургууль” болон “Гал унтраах техникийн олон төрөлт спортын 2022 оны Улсын аварга шалгаруулах тэмцээн”-д Онцгой байдлын газрын бие бүрэлдэхүүнийг хамруулахад шаардагдах шатахууны зардал 2,349,500 (хоёр сая гурван зуун дөчин есөн мянга таван зуу) төгрөгийг аймгийн Гамшгийн сангаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР